

“ЦУСНЫ ДОНОРЫН ҮНДЭСНИЙ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛСЭН ТАЙЛАН.

Улаанбаатар хот

2025.01.03

Зорилго:

Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс санаачлан жил бүрийн 1 дүгээр сарын 3-ны өдрийг “Цусны донорын Үндэсний өдөр” болгон тэмдэглэн өнгөрүүлэхээр тогтсон.

Сайн дурын авлагагүй цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын үйлсийг сурталчлах, ард иргэд тогтмол хугацаанд цусаа өгөхийн ач холбогдлын талаар ойлголт өгөх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд оршдог.

Цусны донорын Үндэсний өдрийг тэмдэглэх бэлтгэл ажлын хүрээнд:

- ✓ Удирдамж, төсвийг гарган батлуулах;
- ✓ Цусны донорын Үндэсний өдрийн үйл ажиллагаанд оролцох урилга бэлтгэн цахим орчинд байршуулах;
- ✓ Болзол хангасан доноруудад мэдээлэл хүргэх;
- ✓ Шагнал, өргөмжлөл, бэлэг дурсгалын зүйлийг бэлтгэх;
- ✓ Хөтлөгчийн үг, хөтөлбөр, хэвлэлийн мэдээг бэлтгэх ажлуудыг зохион байгуулсан.

Нээлтийн үйл ажиллагаа:

Нээлтийн үйл ажиллагааг 2025 оны 01 сарын 03-ны өдрийн 11 цагт ЦССҮТ-ийн төв байранд зохион байгууллаа.

Нээлтэд Ерөнхий захирал АУ-ны доктор, профессор Н.Эрдэнэбаяр, хамтран зохион байгуулагч МУЗН-ийн НХЭМГ-ийн дарга Б.Гантулга, Монголын донорын холбооны ерөнхийлөгч, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан М.Сосорбарам, МДХ ТББ-ын гүйцэтгэх захирал Мандах нар оролцон үг хэллээ.

Залуу дуучин, Voice of Mongolia наадмын шилдэг оролцогч Д.Бямбасүрэн буюу артист ДЭРБИ нийгмийн хариуцлагынхаа хүрээнд эрхэм донорууддаа ая дууныхаа дээжээс өргөн барьж, талархал илэрхийллээ.



Алдаршуулалт:

Уг арга хэмжээний үеэр 101 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгч Мөнгөн донорын болзол хангасан Хүндэт донор Цэенхорлоогийн Өлзийхишиг, 100 удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Даваагийн Ган-Очир, 70 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн Дугарсүрэнгийн Сарантуяа, Самдангийн Дарамбазар нарыг “Хүрэл донор”-оор өргөмжилж алдаршууллаа.



2024 онд хамгийн олон удаа цусаа бэлэглэсэн донороор Мажигсүрэнгийн Мөнгөнхүү (17), Бямбажавын Даваажав (14) нар тодорлоо.



МУЗН-ийн шагналаар:

Авлагагүй сайн дурын цусны донорын эгнээг өргөжүүлэх нийгэм хүмүүнлэгийн үйл ажиллагааг дэмжиж хамтран зохион байгуулахын дээр нийт 32 удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн Жаргалсайханы Нарантуяаг МУЗН-ийн Нигүүлсэл алтан медаль, 26 удаа цус цусны бүрэлдэхүүн хэсгээ бэлэглэсэн ИНЕГ-ын ажилтан Наранцэцэгийн Ганзоригийг Нигүүлсэл мөнгөн медалиар шагнаж алдаршууллаа.



35 ба түүнээс олон удаа цус, цусны бүрэлдэхүүн хэсгээ өгсөн доноруудыг МУЗН-ийн нэр хүндтэй шагнал Хүндэт донор цол тэмдгээр шагнадаг. Хүндэт донор цол тэмдгийг жилд 2 удаа буюу Цусны донорын Д1элхийн өдөр, Цусаа бэлэглэх Үндэсний өдрийг тохиолдуулан олгодог. Энэ өдөр “Хүндэт донор”-ын болзол хангасан 43 донорт цол тэмдгийг гарын бэлгийн хамт гардууллаа.



Хэвлэл мэдээллийн ажилтан Шагналын болзол хангасан доноруудын төлөөлөл, энэ өдөр цусаа анх удаа өгсөн 12 дугаар ангийн сурагч И.Хүслэн нартай ярилцлага мэдээлэл хийж, мэдээлэл бэлтгэн цахимд байршуулж алдаршуулсан.

Тайлан бичсэн:

Захиргаа, маркетингийн албаны дарга

Ч.Батболд